



МОНГОЛ УЛС  
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/57

Чингис хот

Улсын нөөцийн өвс татан авахад  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.9, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 212 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын №01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын нөөцөөс өвс, тэжээл олгох, тэжээл нөхөн бүрдүүлэх тухай Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 212 дугаар тогтоолын дагуу Дорнод аймгийн Онцгой байдлын газар дахь улсын нөөцийн салбараас 100 тн буюу 5000 боодол өвсийг татан авахад шаардагдах 9.000.000 /есөн сая/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын гамшгийн эрсдэлийг бууруулах сангийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

4. Дорнод аймгийн Онцгой байдлын газар дахь улсын нөөцийн салбараас өвсийг татан авах ажлыг зохион байгуулахыг Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/, ирсэн өвсийг буулгаж өвөлжилт хүндэрсэн сумдад хуваарь гарган олгохыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /Ж.Энх-Амгалан/-т тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010170

02 Аймгийн Засаг даргын 2021 оны  
... дугаар сарын 02 өдрийн А/57  
дугаар захирамжийн хавсралт

ШАТАХУУН ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Байгууллагын нэр	Автомашин марк	Туулах зам /км/	Өвс	Нэг бүрийн үнэ	Зарцуулах шатахуун	Нийт үнэ
1	Онцгой байдлын газар	Уаз-220695 фургон	1400		1850	270	500.000
2	99 Маркет			5000	1700		8.500.000
Нийт							9.000.000